БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН
АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ӨЛГИЙ СУМЫН 5 ДУГААР БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН**

**2016 оны 12 дугаар сарын 31-нээр**

**дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан**

**Аудитын код: БӨА-2017/140/СТА-ТШЗ**

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл дараах хаягаар харилцана уу:

Цахим хуудас: http:/ahlah5-ulgii.edu.mn/

Тэргүүлэх аудитор: М.Хуанган

Утас: 99417382 Цахим хаяг: mhkuangan@yahoo.com

Аудитын менежер: Х.Женисбек

Утас: 70422930, 99932710 Цахим хаяг: kh_jenisbek@yahoo.com

Ахлах аудитор:

Утас: Цахим хаяг:

## Агуулга


1 Аудитын гэрчилгээ ..... 2

2 Аудитын тайлан ..... 4

2.1 Оршил ..... 4

2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага ..... 4

2.3 Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт ..... 5

2.4 Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин ..... 5

2.5 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ ..... 6

2.6 Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал ..... 6

2.7 Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар ..... 6

2.8 Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн ..... 7

2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл ..... 8

2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал ..... 8

2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал ..... 8

2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал ..... 8

2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал 8

2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал ..... 8

2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга ..... 8

2.12 Шилэн дансны мэдээлэл ..... 9

2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга ..... 9

2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл ..... 9

3 Менежментийн захидал ..... 11

3.1 «management_zurchil1» ..... **Error! Bookmark not defined.**

3.2 «management_zurchil2» ..... **Error! Bookmark not defined.**

4 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл ..... 12

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан ..... 12

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан ..... 14

4.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан .. **Error! Bookmark not defined.**

4.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан ..... 18

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан ..... 22

# 1 Аудитын гэрчилгээ

ӨЛГИЙ СУМЫН 5 ДУГААР БҮРЭН ДУНД СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Г.АМАНТАЙ ТАНАА


**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА**
**БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН**
**АУДИТЫН ГАЗАР**
83129 Өлгий сум, Баян-Өлгий аймаг,
Утас/факс:(976) 7042-2954
E-mail: bayanulgii@audit.gov.mn


2017.02.24 № 33 БӨА-2017/110/177-703
танай ___________-ны №_______________-т

Аудитын гэрчилгээ

Өлгий сумын 5 дугаар бүрэн дунд сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх дуусвар болсон, аккруэл сууриар бэлтгэгдсэн, жилийн эцсийн санхүүгийн тайланд Төрийн аудитын тухай хуулийн 15.1.1-д заасан бүрэн эрхийн дагуу ҮАГ-ын харьяа Баян-Өлгий аймгийн Аудитын газраас аудит хийв.

Аймгийн Өлгий сумын 5 дугаар бүрэн дунд сургуулийн нь тайлант хугацааны санхүүгийн тайланг холбогдох хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу үнэн зөв бэлтгэж, тайлагнах үүрэг, хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллага нь Өлгий сумын 5 дугаар бүрэн дунд сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, санал дүгнэлт өгөх үүрэг, хариуцлага хүлээнэ.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журам нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Өлгий сумын 5 дугаар бүрэн дунд сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэлийн хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем, гол хууль тогтоомжуудын мөрдөлтийг болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

1

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай бөгөөд зохистой үндэслэлийг бүрдүүлсэн.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Өлгий сумын 5 дугаар бүрэн дунд сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлан, илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР М.ХУАНГАН

2

# 2 Аудитын тайлан

## 2.1 Оршил

Өлгий сумын 5 дугаар бүрэн дунд сургуулийн захирал Г.Амантай танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг биш алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж, оруулав.

## 2.2 Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд энэ хуулийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1 дах заалтыг хэрэгжүүлэх зорилгоор Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийлээ.

Аудитыг төлөвлөлтийн шатанд боловсруулсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн гаргасан төр, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2017 оны 2 сарын 21-нээс 2017 оны 2 сарын 24-ны хооронд хийж, аудитын тайланг 2017 оны 2 сарын 24-нд эцэслэн баталгаажуулж, үйлчлүүлэгчийн удирдлагад хүргүүлэхээр төлөвлөн, Аймгийн аудитын газрын аудитор М.Айнур хариуцаж хэрэгжүүлэв.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа 2017 оны 1 сарын 25-нд төрийн

аудитын байгууллагад 2017 оны 1 сарын 25-ны өдрийн №22–р албан бичгээр ирүүлсэн байна.

## 2.3 **Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт**

Аудитын явцад Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн аудитын журам, гарын авлагад дурдсан аудитыг төлөвлөх, гүйцэтгэх, тайлагнах үе шатны ажлыг гүйцэтгэж, баримтжуулан Санхүүгийн тайлангийн аудитын удирдлагын системд оруулсан бөгөөд аудитад баримтласан бодлого, стандарт, зарчим, үйл явцын талаарх мэдээллийг аудитын санал дүгнэлтэд тодорхойлсон болно.

Аудитын үйл явц, үр дүнг Аудитын олон улсын стандартын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудит хийхэд Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандарт, Санхүүгийн аудитын удирдамж – Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт 1000 – 1810, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчмуудад тулгуурлав.

## **2.4 БАЙГУУЛЛАГЫН ЗОРИЛГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА, ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН ОРЧИН**

Бид Аудитын олон стандартад заасны дагуу үйлчлүүлэгч байгууллагын үйл ажиллагаа, гадаад дотоод орчны талаар төлөвлөсөн бодлого, журмын дагуу шаардлагатай гэж үзсэн хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургууль нь “Өөрөө өөртөө итгэлтэй, эрүүл хүүхэд төлөвшүүлэх” эрхэм зорилгын дор Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээнд дараах үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургууль нь дээрх хуулиар тогтоосон чиг үүрэг, үйл ажиллагааны хүрээнд өөрийн эрхэлэх асуудал, үйл ажиллагааныхаа чиглэл, цар хүрээг дараах байдлаар тодорхойлж баталгаажуулжээ. Үүнд:

Тайлант хугацаанд Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургууль “Хүүхдүүдийн монгол хэлний ярих чадварыг сайжруулах” зорилт дэвшүүлэн ажиллажээ.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, ТАБ-СТА-Б-2.1 маягтаар баталгаажуулсан болно.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль

## 2.5 НЯГТЛАН БОДОХ БҮРТГЭЛИЙН БОДЛОГО, ҮЙЛ АЖИЛЛАГАА БОЛОН ДОТООД ХЯНАЛТТАЙ ХОЛБООТОЙ ХҮЧИН ЗҮЙЛСИЙН ҮНЭЛГЭЭ

Бид санхүүгийн нэгтгэсэн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд 2 буюу мэдээллийн технологийн мэргэжилтэн аудитад татан оролцуулах 2 гэж үзлээ.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургууль нь санхүүгийн тайлан, тодруулга, төсвийн гүйцэтгэлийн тайлан бэлтгэх, ажил гүйлгээг бүртгэх, хянах үйл ажиллагаанд санхүүгийн “Аколоус” програм хангамж ашиглажээ.

## 2.6 ТӨЛӨВЛӨЛТИЙН ШАТАНД ТОДОРХОЙЛСОН ЭРСДЭЛ, ТҮҮНИЙГ ҮНЭЛСЭН БАЙДАЛ

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой уламжлалт болон хяналтын эрсдэлийг илрүүлэх, үнэлэх үе шатны ажлын талаар товч толилуулъя.

Аудитыг төлөвлөх үе шатанд байгууллага, түүний гадаад, дотоод орчны талаарх цуглуулсан мэдээлэл, ойлголтод үндэслэн эрсдэлийн үнэлгээний горим хэрэгжүүлэн 21 эрсдэлтэй асуудал тодорхойлон, тэдгээрийг ТАБ-СТА-Б-2.6 маягтад нэгтгэж, баримтжуулав.

Дээрх эрсдэлтэй асуудал тус бүрийг дахин нарийвчлан үнэлэхэд 1 асуудал эрсдэл өндөр, 3 асуудал эрсдэл дунд гэсэн үр дүн гарлаа.

Эрсдэлийн ерөнхий үнэлгээг ТАБ-СТА-Б-4.3 маягтад нэгтгэн баримтжуулсан бөгөөд нийт эрсдэлийн үнэлгээний түвшин 9 байна.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн эрсдэл өндөр буюу зайлшгүй шалгах эрсдэлтэй 1 асуудлыг аудитын чиглэл тус бүрээр нэгтгэж, тэдгээрийг сорих – шалгах аудитын горим сорил, шалгуур үзүүлэлт, нотлох зүйл цуглуулах арга замыг холбогдох маягтаар баримтжуулан баталгаажуулсан болно.

## 2.7 МАТЕРИАЛЛАГ БАЙДЛЫН СУУРЬ СОНГОСОН ҮНДЭСЛЭЛ, ТАЙЛБАР

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үеийн материаллаг байдлыг Аудитын олон улсын стандарт 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн -ийг сонгов.

Санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлогыг материаллаг байдлын суурь үзүүлэлтээр сонгосонтай холбоотой юм.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт орлого 1766,2 сая төгрөг бөгөөд түүний 2 хувь 35,2 сая төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажууллаа.

Материаллаг байдлыг суурь үзүүлэлтээс тооцох хувийг 2 хувиар тооцсоныг хангалттай гэж үзлээ.

## 2.8 АУДИТЫН ЯВЦАД ХЭРЭГЖҮҮЛСЭН ГОРИМ СОРИЛ, ТҮҮНИЙ ҮР ДҮН

Аудитыг төлөвлөх шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, төлөвлөсөн ёсоор аудитын 6 чиглэлээр 21 эрсдэлтэй асуудалд 21 горим, сорил хэрэгжүүлж, түүний үр дүнг баримтжуулав. /ТАБ-СТА-В-3.1/

Харин аудитыг төлөвлөх шатанд эрсдэлтэй гэж тооцсон боловч, аудитын горим сорил хэрэгжүүлэх явцад алдаа зөрчилгүй нь тогтоогдсон асуудлыг ТАБ-СТА-В-4.2 маягтаар нэгтгэж, баримтжуулав.

Алдаа зөрчилтэй буюу буруу илэрхийллийн нэгтгэлээс аудитын явцад залруулах боломжтой эсэх асуудлыг ТАБ-СТА-В-4.3 маягтад шийдвэрлэж, залруулах боломжтой асуудал буюу залруулгын талаарх мэдээллийг ТАБ-СТА-В-4.4, ТАБ-СТА-В-4.5 маягтуудад нэгтгэж, баримтжуулсан.

Харин санхүүгийн тайлан, тодруулга дах залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудалд дүн шинжилгээ хийж, алдаа зөрчлийг дараах байдлаар ангилав.

(Сая төгрөгөөр)

| № | Буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг ангилсан байдал | Тоо | Дүн | Тайлбар |
|---|---|---|---|---|
| 1 | Зөвлөмж болгосон асуудал | 0 | 0 | |
| 2 | Төлбөрийн акт тогтоосон | 0 | 0 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 0 | 0 | |
| 4 | Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн | 0 | 0 | |
| 5 | Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн | 0 | 0 | |
| | Дүн | 0 | 0.0 | |

Дээрх зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүй жагсаалтыг ТАБ-СТА-В-4.6.1-5 маягтад нэгтгэн баримтжуулав.

## 2.9 Аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал, гаргасан шийдэл

Аудитаар санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэх хэмжээний алдаа зөрчилтэй асуудал ирээгүй болно.Харин бусад материаллаг буруу илэрхийлэл буюу алдаа зөрчилтэй асуудлыг хэрхэн шийдвэрлэсэн байдлаар дараах заалтад ангилан харуулав.

### 2.9.1 Төлбөрийн акт тогтоосон алдаа, зөрчилтэй асуудал

*үгүй*

### 2.9.2 Албан шаардлага өгсөн алдаа, зөрчилтэй асуудал

*үгүй*

### 2.9.3 Сахилгын шийтгэл ногдуулахаар шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

*үгүй*

### 2.9.4 Хууль хяналтын байгууллагад асуудлыг шилжүүлсэн алдаа, зөрчилтэй асуудал

*үгүй*

## 2.10 Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Цалин тогтоолт, цалин олголтын байдалд анхаарал хандуулах нь зүйтэй.

## 2.11 Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар батлагдсан төсвийн гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулж, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургууль нь өөрийн чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой хөтөлбөр, арга хэмжээнд зориулан урсгал зардалд 1732,4 сая төгрөгийн төсөв баталсан байна. Батлагдсан төсөв, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг дор нэгтгэн харуулав.

/Сая төгрөгөөр/

| № | Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Хувь | Зөрүү |
|---|---|---|---|---|---|
| 1 | Нийт зарлага ба цэвэр зээлийн дүн | 1732,4 | 1729,0 | -0.2% | 3 |
| 1.1 | Урсгал зардал | 1732,4 | 1729,0 | -0.2% | -3,7 |
| 1.2 | Хөрөнгийн зардал | 0 | 0 | 0.0% | 0.0 |
| 1.3 | Эргэж төлөгдөх төлбөрийг хассан цэвэр зээл | 0 | 0 | 0.0% | 0.0 |
| 2 | Зардлыг санхүүжүүлэх эх үүсвэр | 1732,4 | 1729,0 | | |
| 2.1 | Улсын төсвөөс санхүүжих | 1732,2 | 1728,4 | | |
| 2.2 | Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих | | | | |
| 2.3 | Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос | 0,2 | 0,6 | | |

Төсөвт зардлын гүйцэтгэл 99,8 хувь байгаа нь төсвийн санхүүжилтээс 3,7 сая төгрөгийг төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд төсөвт байгууллагын үйл ажиллагаанаас төвлөрүүлэх орлогын биелэлт 2,75 хувь байгаа нь өөрийн орлогыг 0,3 сая төгрөгөөр давуулан биелүүлсэнтэй холбоотой байна.

Тайлант хугацаанд Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийн дансаар нийт 4,8 сая төгрөг зарцуулсны дотор урсгал зардалд 4,8 сая төгрөг байна.Дээрх зардлыг санхүүжүүлсэн эх үүсвэрийг ангилал тус бүрээр нэмэлт төвсийн тайлангаар баримтжуулан баталгаажуулав.

## 2.12 Шилэн дансны мэдээлэл

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургууль Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус байгууллагын Шилэн дансны хуулиар хүлээсэн үүргийн биелэлтийг төлөвлөсөн хэмжээнд хянаж, баримтжуулсан болно.

## 2.13 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

## 2.14 Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг

Аудитын Олон улсын стандартын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Өлгий сумын 5 дугаар Бүрэн дунд сургуулийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн болон бусад илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүдээ холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг байдлын хувьд алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн байна гэж үзэж “Зөрчилгүй” санал дүгнэлт гаргалаа.

Аудитын явцад илэрсэн залруулаагүй буруу илэрхийлэл буюу алдаа зөрчлийг энэ тайлангийн 2.8-д нэгтгэн тусгасан бөгөөд эдгээр буруу илэрхийлэл буюу алдаа, зөрчлийн дүн материаллаг байдлын түвшингээс бага байгаа тул аудитын санал дүгнэлтийг хязгаарлах үндэслэлгүй байна.

Аудитын санал дүгнэлтийг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

# 3 МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү аудитаар менежментийн захидал өгөгдөөгүй болно. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

# 4 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

## 4.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

**СТ-1А**

**САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| **1** | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **34,559,543.00** | **25,082,388.00** |
| **31** | **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | 10,000.00 | - |
| **311** | **Кассанд байгаа бэлэн мөнгө** | - | - |
| 31110 | Төгрөг | | |
| 31130 | Нэмэлт санхүүжилт | | |
| 31140 | Касс арилжааны банк | | |
| **312** | **Банкинд байгаа бэлэн мөнгө** | 10,000.00 | - |
| **3121** | **Төгрөг** | 10,000.00 | - |
| 31211 | Төрийн сангийн харилцах | 10,000.00 | - |
| 31212 | Монгол банкин дахь харилцах | | |
| 31213 | Арилжааны банк дахь харилцах | | |
| 31215 | Нэмэлт санхүүжилтийн харилцах | | |
| 31216 | Нэмэлт санхүүжилтийн арилжааны банк | | |
| **33** | **АВЛАГА** | 10,518,868.00 | - |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | | |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | |
| **335** | **Бусад авлага** | 10,518,868.00 | - |
| 3351 | Байгууллагаас авах авлага | | |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 10,518,868.00 | - |
| **35** | **БАРАА МАТЕРИАЛ** | 24,030,675.00 | 25,082,388.00 |
| **351** | **Түүхий эд материал** | - | - |
| 35110 | Тусгай зориулалттай материал | | |
| 35130 | Эм боох материал | | |
| 35200 | Дуусаагүй үйлдвэрлэл | | |
| 35300 | Бэлэн бүтээгдэхүүн | | |
| **354** | **Хангамжийн материал** | 24,030,675.00 | 25,082,388.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,846,779.00 | 5,691,769.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 9,269,238.00 | 9,475,961.00 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | | |

| | | | |
|---|---|---|---|
| 35440 | Түлш, шатах тослох материал | | |
| 35450 | Барилгын засварын материал | | |
| 35460 | Хүнсний материал | | |
| 35470 | Бусад хангамжийн материал | 9,914,658.00 | 9,914,658.00 |
| 35500 | Биологийн хөрөнгө | | |
| 35600 | Мал амьтад | | |
| **2** | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **1,337,939,975.48** | **1,304,369,734.33** |
| **39** | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 1,337,939,975.48 | 1,304,369,734.33 |
| 391 | Газар | | |
| **392** | **Биет хөрөнгө** | 1,337,939,975.48 | 1,304,369,734.33 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,263,156,970.00 | 1,271,167,002.00 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -297,779,894.97 | -327,957,508.41 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 00.00 | 00.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | 00.00 | 00.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 310,031,441.00 | 318,058,381.00 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -42,437,998.96 | -71,903,835.81 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 99,263,179.00 | 109,498,254.00 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -58,733,390.59 | -65,565,957.45 |
| 39209 | Зам, гүүрийн байгууламж | | |
| 39210 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39211 | Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж | | |
| 39212 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39213 | Түүх соёл, музейн дурсгалт зүйлс | | |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | | |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39216 | Дуусаагүй барилга, байгууламж | | |
| 39217 | Ном | 64,439,670.00 | 71,073,399.00 |
| **393** | **Биет бус хөрөнгө** | - | - |
| 39301 | Програм хангамж | | |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | | |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 550,000.00 | 550,000.00 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | -550,000.00 | -550,000.00 |
| **3** | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,372,499,518.48** | **1,329,452,122.33** |
| **4** | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **17,284,601.00** | **-** |
| **413** | **Өглөг** | 17,284,601.00 | - |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 980,716.00 | |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | | |
| 41330 | Татаас, санхүүжилт, шилжүүлгийн өглөг | | |
| 41340 | Хөрөнгө бэлтгэхтэй холбогдсон өглөг | | |
| 41350 | Зээлийн хүүгийн өглөг | | |

| | | | |
|---|---|---|---|
| **4136** | **Бусад өглөг** | 16,303,885.00 | - |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 14,673,685.00 | 00.00 |
| 41362 | Хувь хүмүүст төлөх өглөг | 1,630,200.00 | 00.00 |
| **5** | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,355,214,917.48** | **1,329,452,122.33** |
| **51** | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,355,214,917.48 | 1,329,452,122.33 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 724,746,698.00 | 724,746,698.00 |
| 51101 | Өмч: - төрийн | 724,746,698.00 | 724,746,698.00 |
| 51102 | - хувийн | | |
| 51103 | - хувьцаат | | |
| 51104 | Халаасны хувьцаа | | |
| 51105 | Нэмж төлөгдсөн капитал | | |
| 51106 | Эздийн өмчийн бусад хэсэг | | |
| **512** | **Хуримтлагдсан үр дүн** | 115,317,341.48 | 89,554,546.33 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 115,317,341.48 | 115,317,341.48 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | -25,762,795.15 |
| 51230 | Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс | | |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 515,150,878.00 | 515,150,878.00 |
| **6** | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,372,499,518.48** | **1,329,452,122.33** |

## 4.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

**СТ-2А**

**САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН**

/Төгрөгөөр/

| **Дансны код** | **Үзүүлэлт** | **Өмнөх оны гүйцэтгэл** | **Тайлант оны гүйцэтгэл** |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,922,487,051.00** | **1,766,209,308.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **246,484,076.00** | **28,049,471.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 246,484,076.00 | 28,049,471.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 246,484,076.00 | 28,049,471.00 |
| 1200041 | Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 244,919.00 | 551,527.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | - | - |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | - | - |
| 1200044 | Гадаадын эх үүсвэрээс санхүүжих | - | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 246,239,157.00 | 27,497,944.00 |
| 120009 | Бусад орлого | | |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,676,002,975.00** | **1,738,159,837.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,595,357,900.00 | 1,732,165,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | | |
| 131002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | |
| 131003 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | |

| | | | |
|---|---|---|---|
| 131004 | Төсөв болон дамжуулан зээлдүүлсэн зээлээс эргэж төлөгдөх | | |
| 131005 | Хөрөнгийн санхүүжилт | | |
| 131006 | Засгийн газрын тусгай сангаас санхүүжих | | |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 1,595,357,900.00 | 1,732,165,600.00 |
| 131008 | Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас санхүүжих | | |
| 131009 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих | | |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 4,847,832.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | | |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | | |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 00.00 | 4,847,832.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | | |
| 131106 | Төсвийн урамшуулал | | |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | 57,062,358.00 | - |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | | |
| 132002 | Засгийн газрын, Засаг даргын нөөц хөрөнгийн санхүүжилт | | |
| 132003 | Төвлөрүүлэх шилжүүлэг /орон нутгийн төсөвт байгууллага улсад төвлөрүүлэх орлого/ | | |
| 132004 | Оны эхний үлдэгдлээс санхүүжих / орон нутгийн төсөв/ | | |
| 132005 | Хөрөнгийн санхүүжилт / орон нутгийн төсөвт байгууллага/ | 57,062,358.00 | 00.00 |
| 132006 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт / аймгаас авсан санхүүгийн дэмжлэг/ | | |
| 132007 | Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих | | |
| **1340** | **Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих** | 23,582,717.00 | 1,146,405.00 |
| 134001 | Нийгмийн даатгалын сангаас санхүүжих | 23,582,717.00 | 1,146,405.00 |
| 134002 | Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих | | |
| 134003 | Нийгмийн даатгалын сангаас эмнэлгүүдэд олгох санхүүжилт | | |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,661,318,713.55** | **1,791,972,103.15** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,661,318,713.55** | **1,791,972,103.15** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 1,510,803,721.55 | 1,604,758,641.15 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 1,258,801,592.00 | 1,301,000,276.00 |
| 210101 | Үндсэн цалин | 1,182,619,388.00 | 1,245,788,892.00 |
| 210102 | Нэмэгдэл | 00.00 | 00.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 00.00 | 00.00 |
| 210104 | Урамшуулал | 76,182,204.00 | 55,211,384.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | | |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 136,910,556.00 | 143,639,334.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 136,910,556.00 | 119,669,521.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 00.00 | 4,667,923.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 00.00 | 3,429,260.00 |

| | | | |
|---|---|---|---|
